



Нягтлаарай! Унадаг дугуйны замын дүрэм

2026 оны 4-р сараас эхлэн хууль зөрчсөн жолоодлогод зөрчлийн төлбөр ноогдуулдаг болно.



Дугуйг тээврийн хэрэгсэл болгон ашигладаг хүн болон байдаг болов уу. Дугуйны замын ослоос сэргийлэхийн тулд зөв замын дүрмийг дахин нэг нягталж үзэцгээе.

Дугуй унахдаа ~Мөрдөх 5 чухал зүйл~

- 1 Автомашины замын зүүн талаар зорчоорой. Унадаг дугуй нь автомашины төрөлд хамрагддаг тул, зарим хамааралгүй тохиолдлыг үл тооцон, автомашины замын зүүн талаар зорчих ёстой. Дугуйгаар зорчих боломжтой явган хүний зам дээр ч гэсэн явган хүн түрүүнд нь зорчино. Дугуйгаар зорчихдоо, автомашины замд ойрхон талаар нь хурдаа сааруулж зорчоорой.
- 2 Замын уулзвар дээр, гэрлэн дохио болон “Зогсох тэмдэг”-ийг дагаж мөрдөн, аюулгүй байдлыг магадлаарай.
- 3 Орой, шөнийн цагаар зорчихдоо, дугуйныхаа гэрлийг заавал асаагаарай.
- 4 Согтууруулах ундаа уусны дараа дугуй унаж болохгүй.
- 5 Ослын улмаас үүсэх хохирлыг багасгахын тулд, толгойны хамгаалалт өмсөхийг хичээгээрэй.



Түүнээс гадна, дугуй унангаа гар утсаа харах, эсвэл гартаа шүхэр барьж дугуй унахыг хориглодог.

Дагаж мөрдөхгүй бол зөрчлийн төлбөр ноогдоно!



Эдгээр дүрмийг баримтлаагүй тохиолдолд хариуцлага тооцдог бөгөөд 2026 оны 4-р сараас эхлэн, автомашин, мотоциклын нэгэн адилаар, дүрэм зөрчсөн этгээдэд зөрчлийн төлбөр хураалгахыг шаардах хяналт хийгдэх болно. Тухайлбал, гар утасны “Анхаарал сарнисан жолоодлого”-д 12,000 иен, орой, шөнийн цагаар гэрлээ асаалгүй зорчсон тохиолдолд 5,000 иен гэх зэргээр төлбөр төлөх шаардлагатай болно. Замын дүрмийг чандлан баримталж, аюулгүй зорчихыг хичээгээрэй.

出典：「広報けいしちょう」春号（第111号）より抜粋し、JITCOが作成

Үзэж суралцах замын дүрэм

JITCO сургалтын материалын онлайн дэлгүүрт DVD “Q&A-аар үзэх Японы замын аюулгүй байдал ~ Явган зорчих болон дугуйгаар зорчих дүрэм ~”-ийг худалдаалж байна. Япон, Хятад, Англи, Индонези, Вьетнам гэсэн 5 хэлээр бичлэг хийсэн. Та бүхнийг үзэхийг урьж байна.



Q&Aで覚える日本の交通安全
～歩行と自転車のルール～